

ЦУСНЫ ДОНОРЫН ТУХАЙ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ

2025 оны 05 дугаар
сарын 20-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа

Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, Ж.Алдаржавхлан, А.Ариунзаяа, Н.Батсүмбэрэл нараас 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Цусны донорын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Нийгмийн бодлогын байнгын хороо 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагчид цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамжийн тасралтгүй байдлыг хангах, цус сэлбэлт судлалын салбарын зохион байгуулалтыг боловсронгуй болгох замаар цусны салбар төвүүдийн статус, дэлхий нийтээр баримталж байгаа “нэгдсэн тогтолцоо”-нд үе шаттайгаар шилжих асуудлыг тодорхой болгох, цусны донор, цус сэлбүүлэгчид тавигдах шаардлага, тэдний эрх, үүрэг, тэдэнд эрүүл мэндийн үзлэг хийх, цус, түүний бүрэлдэхүүн хэсэг авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, цус, цусан бүтээгдэхүүнийг эмнэлгийн хэрэгцээнд хэрэглэхтэй холбоотой зохицуулалтыг нарийвчлан бий болгох шаардлагатай бөгөөд хуулийн төслийг баталснаар цусны донорын үйл ажиллагаан дахь төрийн зохицуулалт, хяналт сайжирч, цус сэлбэлт судлалын тусламж, үйлчилгээний удирдлагын тогтолцоотой холбоотой харилцаа бүрэн зохицуулагдах боломж бүрдэнэ гэж үзсэн байна.

Цусны донорын үйл ажиллагааны санхүүжилт нь улсын болон орон нутгийн төсөв, цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагын өөрийн орлого, аж ахуйн нэгж, байгууллага, хамт олон, иргэний хандив, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдэх бөгөөд хүний нөөцийн зардал, материаллаг зардал, бусад зардалд нийт 14 тэрбум төгрөгийн зардал гарч, үүнийг улсын төсвөөс нэмэлт эх үүсвэр шаардахгүйгээр байгууллагын өөрийн орлогоор эхний ээлжинд зохион байгуулах боломжтой, цаашид техник, технологийн шинэчлэлтэй холбоотой хөрөнгө оруулалтын зардал улсын төсөвт тусгагдана гэж хууль санаачлагчид үзжээ.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийг үндэслэн Цусны донорын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн талаарх хууль зүйн дүгнэлтийг ирүүлсэн.

Хуулийн төслийг d.parliament.mn цахим хуудаст байршуулж иргэд, олон нийтийн санал авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат цусны донорыг урамшуулах, татвараас хөнгөлөх асуудлыг хуулийн төсөлд тусгах боломжтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт заасан

Цусны төвийг байгуулахад шаардагдах санхүүжилт, эдийн засгийн тооцоо судалгааны талаар, Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан хуулийн төслийг баталснаар төсөвт үзүүлэх нөлөөллийн талаар тус тус асуулт асууж, хариулт авсан.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд санал хэлээгүй болно.


Цусны донорын тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 52,9 хувийн саналаар, хамт өргөн мэдүүлсэн Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 58,8 хувийн саналаар үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн бол, хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Цусны донорын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай, Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**



Л.ЭНХНАСАН